

I.E. REPIN ACADEMY EDUCATION IN MONGOLIAN PRINTMAKING ARTS

DOI - <https://doi.org/10.69561/mjac.v25i47.3471>

Ulziibayar Dondov

Doctor (Ph.D), Mongolian Academy of Fine Arts, Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author: uuujii802@gmail.com

Abstract: Academism emerged in Europe from XVI to XIX centuries, characterized by a dogmatic adherence to the external forms of classical art. This movement played a pivotal role in the organization of art education and the standardization of the classical tradition, viewed as an ‘eternal’ law and system. During XVII and XVIII centuries, Academism extended its influence to countries such as England, France, and Russia, with the Imperial Russian Academy standing out as the most powerful and influential. Throughout the history of global visual arts education, there has been an intense debate surrounding the concept of academic training or academism, and it is evident that this discussion will persist in the future. In the history of global visual arts education, a vigorous debate has unfolded around the concept of academic training or academism, and it is evident that this discourse will persist into the future. The Russian Imperial Academy of Fine Arts, having matured within Western art traditions for centuries, has successfully navigated into the XXI century by blending tradition and innovation in sync with the pace of time. Since L.Gavaa, the first Mongolian artist, undertook studies at the Academy of Fine Arts in 1952, 70 artists have graduated, exemplifying the clear formation and development of classical education in Mongolian fine arts. Our study will focus on the teaching methodologies of the following two artists and educators who have inherited I.E. Repin’s school of art, passing it down to the next generation, and who continue this tradition and contribute to the education of Mongolian visual arts - Ya. Oyunchimeg, an Honored Worker of the Art of Mongolia and Associate Professor, Artist, and Z. Uyanga, a teacher and an Award-winning artist of the Mongolian Craftsmen’s Union Committee.

Key words: *academicism, peintmaking, tradition, prints, silkscreen print*

Оршил

И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академи, Парис дахь Дүрслэх урлагийн төв академи, Лондон дахь Хатан хааны Дүрслэх урлагийн академи, Берлиний Урлагийн их сургуулиудыг “Дэлхийн дүрслэх урлагийн дөрвөн том академи” гэдэг. Эдгээр академиудад дэлхийн хэмжээний уран бүтээлчийг бэлтгэсээр байна.

И.Е.Репин, В.И.Суриков, А.И.Куинджи, И.И.Шишкин, В.М.Васнецов, М.А.Врубель зэрэг олон мастерууд тус академиас төржээ. Тэдний бүтээсэн олон уран бүтээлүүд дэлхийн урлагийн түүхэнд шинэ хуудсыг нэмсэн билээ. 1960-аад оноос хойш манай улсын дүрслэх урлаг, утга зохиол, дуу, хөгжим, бүжгийн

урлагийн мастерууд оросын сонгодог урлагт гүн гүнзгий татагдаж эхэлсэн байдаг. Манай оронд орчин үеийн дүрслэх урлагийг хөгжүүлэхэд И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академийн үзүүлсэн нөлөө, харилцан хамтын ажиллагааны жин дарах байдал бусад улс орны урлагийн сургуулиудаас илүү, нэр хүндтэй байр суурь эзэлдэг. Оросын дүрслэх урлагийн нөлөө нь монголын дүрслэх урлагийн хөгжлийн хуудсыг шинэчлэн нээхэд ихээхэн түлхэц болсон юм.

1921 оноос Монгол ардын нам, төрөөс урлаг, утга зохиолыг хөгжүүлэх талаар анхаарал тавьж, ард түмний эрх ашигт нийцсэн агуулгатай, үндэсний хэлбэртэй урлаг соёлыг хөгжүүлэх, дэлхий дахины сонгодог урлагийг бүтээлчээр суралцах зорилт (Л.Сономцэрэн, 1989) тавьснаар монголын орчин үеийн дүрслэх урлагийн түүхийн шинэ хуудас нээгдсэн (Дүрслэх урлаг сэтгүүл, 1980) гэж үздэг. Энэ үеэс улс төрийн зурагт хуудас, сонин, сэтгүүлийн зураг чимэглэл, суртал ухуулгын хуудас зэрэгтэй холбоотой зураасан зургийн хөгжлийн шинэ үе шат эхэлсэн (Шүгэр, 1976) юм. БНМАУ-ын анхны дүрслэх урлагийн уран бүтээлчид ЗСБНХУ руу хоёр улсын засгийн газрын гэрээ хэлэлцээрийн дагуу И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академид суралцаж эхэлсэн.

1960-аад оны эхэн үед зарим уран бүтээлч эх орондоо эргэн ирж, урлаг, боловсролын олон төрлийн (Шүгэр, 1976) ажлыг эхлүүлж байсан. Монголын дүрслэх урлагт суурь зураасан зургийн урлаг хүчтэй гарж ирсэн байна. Монголын зураасан зургийн зураачид И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академи, В.И.Суриковын нэрэмжит Уран зургийн академи гэх оросын хоёр их академид суралцаж, монголын дүрслэх урлагийн салбарт шинэчлэл, шинэ урсгал чиглэл, арга техникийг нэвтрүүлж эхэлсэн юм. Эдгээр уран бүтээлчдээс 70 гаруй нь буюу нийт төгсөгчдийн 15 % нь зураасан зургийн мэргэжлээр сурч төгссөнөөс Я.Оюунчимэг ДУДС, ДУДэС-д багшлан зураасан зургийн мэргэжлээр 87 зураач-уран бүтээлч бэлдэн төгсгөсний дээр түүний анхны шавь нарын нэг З.Уянга МУБИС, ДДУС, ДУА-д, Ө.Гандулам ДУДэС, ДДУС, ДУА-д багшлах, уран бүтээл туурвих ажлыг хослуулан, монголын дүрслэх урлагийн салбарт өөрсдийн багшийн адил хүчин зүтгэж, зураасан зургийн төрлөөр олон чадварлаг уран бүтээлч, мэргэжилтэн бэлтгэж байна. Эдгээрээс зураач, багш Я.Оюунчимэг, түүний шавь З.Уянга нарыг сонгож, тэдний уран бүтээл, сургалтын ажлын залгамж холбоог судлан, судалгааны ажил эхлүүлж байна. Учир нь зураач багш З.Уянга уран бүтээлч болох анхны гараагаа Я.Оюунчимэг багшаар заалган эхлүүлсэн шавь нь бөгөөд хоёулаа И.Е.Репиний академийн дэг сургалтаар сурч төгссөн уран бүтээлч багш, шавь тул тэдний заан сургах үйл ажиллагаанд Репиний академийн дэг сургалтын арга барил хэрхэн тусч, монголын зураасан зургийн хөгжилд хэрхэн нөлөөлснийг судлан тодруулах боломжтой гэж таамаглан энэхүү судалгааны ажлыг эхлүүлсэн билээ.

Үндсэн хэсэг

1962-1993 онд И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академид зураасан зургийн арав гаруй зураач боловсрол эзэмшжээ. Тухайлбал, С.Нацагдорж (1962), Ц.Дагваням (1976), Я.Оюунчимэг (1977), Н.Ганболд (1987), Г.Төвсайхан (1987), О.Баатарчулуун (1987), Ө.Цэнд-Аюуш (1986), З.Уянга (1989), Н.Цэнд-Очир

(1989), Ц.Болд (1993) тус тус төгссөн байна. Тэдний багш нар тэр үеийн оросын зураасан зургийг тэргүүлж байсан урлангийн ахлах профессор В.В.Лебедев, В.А.Ветрогонский, А.Ф.Пахомов нарын уран бүтээлч, профессорууд байв (Уранчимэг, 2023).

1960-аад оноос хойш социалист реализм нь тухайн үеийн үзэл суртлын хэрэгцээг хангаж, коммунист үзэл санааны эргэн тойронд хүмүүсийн эв нэгдэл, социалист хамтын нийгэмлэгийн орнуудын эв нэгдэл, нийгмийн шинэ үзэл санааг илэрхийлсэн тэргүүлэх хэв маяг болсон юм. Манай зураасан зургийн урлаг нь цаг үеийн нөхцөл байдлыг зурагт хуудас дээр маш тодоор дүрслэн гаргахад ихээхэн анхаарч байв. Суртал ухуулгын үзэсгэлэнгийн үйл ажиллагааг хөгжүүлэх нь тэр он жилүүдийн өнгийг тодорхойлсон маш чухал ажил байв. Эдгээр үзэсгэлэнгүүдээс хамгийн их онцлог болсон хэмээн үзэж, дурдан тэмдэглэх ёстой нь 1970 онд “В.И.Ленин 100 жил”, 1971 онд “Монгол ардын хувьсгалын 50 жилийн ой”, 1977 онд “Агуу Октябрийн социалист хувьсгалын 60 жилийн ой”, “Хамтын ажиллагааны хөдөлгөөний 20 жил”, “Олон улсын хүүхдийн жил”, 1980 онд “В.И.Лениний мэндэлсний 110 жилийн ой”, 1981 онд “МАХН-ын 60 жил”, 1982 онд “Сансарт анх удаагаа Монгол Улсын иргэн” (Майдар, 1987) байна. Улмаар уламжлалт монгол үндэсний уран зураг, зураасан зураг, уран баримал дэлхийн урлагийн үзэл санаа, ололт амжилтаар дүүрэн хөгжиж, орчин үеийн урлагийн хэлбэрт шилжиж эхэлсэн түүхтэй (Отгонтөгс, 2012). Монгол дүр төрх, шинж чанар бүхий социалист реалист урлагийг Монголд бий болгоход Орос орны хувь нэмэр өндөр ач холбогдолтой байв.

И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академийн төгсөгч, Монгол улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, Монголын Урчуудын эвлэлийн нэрэмжит шагналт, СТА, дэд профессор, зураач Я.Оюунчимэг нь Дүрслэх урлагийн дунд сургууль байхаас эхлэн Дүрслэх урлагийн дээд сургууль болтол нь тус сургуульд нийт 32 жил тасралтгүй багшилж олон арван шавь нарыг зураасан зургийн мэргэжлээр төгсгөсөн багш юм (Зураг 1).



Зураг 1. И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академийн 1977 оны төгсөгчид: барималч Ц.Амгалан, зураач Ё.Өлзийхутаг, зураач До.Болд, зураач С.Элбэгдорж, зураач Б.Пүрэвсүх, барималч Р.Энхтайван, зураач Я.Оюунчимэг

Тодруулбал; Я.Оюунчимэг багш нийт найман удаагийн төгсөлтөөр 87 оюутны дипломын ажлыг удирдаж, зураач-уран бүтээлч болгон төлөвшүүлж, монголын дүрслэх урлагийн салбарын уран бүтээлчдийн эгнээг өргөтгөсөн байна.



Багш Я.Оюунчимэг 1962 онд Дүрслэх урлагийн дунд сургуульд элсэж, Ардын зураач, Төрийн шагналт зураач Д.Амгалан, Ардын зураач Б.Чогсом, Ардын зураач, Төрийн хошой соёрхолт зураач О.Цэвэгжав зэрэг монголын дүрслэх урлагийн салбарын нэрт уран бүтээлч, сурган хүмүүжүүлэгч багш нараар дөрвөн жил хичээл заалгаж суралцан төгсөж, улмаар 1970–1977 онд Ленинград хотын И.Е.Репиний Дүрслэх урлагийн академийг зураасан зургийн мэргэжлээр профессор В.А.Ветрогонскийн урланд амжилттай суралцаж төгсөөд эх орондоо ирж, Дүрслэх урлагийн сургуульдаа зураасан зургийн багшаар ажиллаж эхэлсэн.



Зураг 2. Я.Оюунчимэг “Зүүдний говь” тосон будаг, зотон, 162x113 см

Я.Оюунчимэг багш бүхий л амьдралынхаа турш уран бүтээлийн эрэл хайгуулыг уйгагүй хийж, зураасан зураг, уран зургийн сонгодог болон уламжлалт арга барилыг баяжуулан хөгжүүлсэн өвөрмөц өгүүлэмж, зохиомж, өнгө аястай олон арван бүтээл



Зураг 3. Я.Оюунчимэг “Гийнгоо” төмөр бар, офорт, 58x52.8 см

туурвихдаа монголын дүрслэх урлагт бар зургийн арга дэг нэвтрүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн юм. “Монголын усан будгийн мастер”, “Хөрөг зургийн мастер” хэмээн алдаршсан тэрээр монголын дүрслэх урлагийн хөгжилд хувь нэмрээ оруулсан төдийгүй амьдралынхаа туршид 400 гаруй уран бүтээл туурвиж, бүтээлээс нь монголын уран зургийн галерейн сан хөмрөг болон гадаад, дотоодын галерейн сан хөмрөгт хүндтэй байр суурь эзлэн хадгалагддаг нь түүний уран бүтээлийн чанар чансааг илтгэж буйн илрэл билээ.

Дүрслэх урлагийн ямар ч төрлөөр ажилладаг түүнд оросын академик дүрслэх урлагийн дэг сургалт хаанаас нь ч харсан гүн суусан байдаг.

Я.Оюунчимэг багшийн шавь, монголын зураасан зургийн мастер З.Уянга бол мөн л оюутан шавь нарынхаа хүндлэл хайраар хүрээлэгдсэн уран бүтээлч юм. З.Уянга И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академийн А.Ф.Пахомовын урланд суралцаж, 1989 онд төгсөж ирээд л уран бүтээлийн гараагаа эрч хүч дүүрэн эхлүүлсэн байдаг. 1990 оноос тэрээр Монголын Урчуудын эвлэлийн гишүүн зураачаар элсэн оржээ. 1990 онд монголын уран бүтээлчдийн дунд зохиогдсон “Нууц Товчоо”-ны 750 жилийн ойн үзэсгэлэнд “Бөртэ чоно”, “Аян”, “Хөх Монгол” өнгөт төмөр барын гурван бүтээлээрээ оролцож, хоёрдугаар байрын шагнал хүртсэн нь түүнд зураасан зургийн бүтээлээ цаашид үргэлжлүүлэн хийх их урам өгсөн гэдэг.



Зураг 4. З.Уянга “Хөх Монгол” төмөр бар, 34x34 см, 1990 он



Зураг 5. З.Уянга “Бөртэ чоно” төмөр бар, 40x31

З.Уянга аливаа сэдвийн мөн чанарыг судалж, оюун ухаандаа цэгцлэн боловсруулж, дүрслэлээ уран сайхнаар илэрхийлж чаддаг уран бүтээлч юм. Учир нь амьдралын утга учир, хүн гэдэг ухагдахууныг тайлбарлахыг зорьсон мэт

аз жаргалаас эхлээд хайр дурлал, далд гуниг, гоо үзэсгэлэн, гүн бодролыг түүний бүтээлүүдээс мэдэрнэ. Өөрөөр хэлбэл, Уянга багшийн бүтээлүүдийг нэгтгэн дүгнэж үзвэл, амьдралын баяр баясгалан, сайн сайхныг магтан дуулж, гоо сайхныг хүний сэтгэлийн гүнд мэдэртэл үзүүлж, дээд ухамсар, оюун санаа хязгааргүй гэдгийг батлах шиг санагдана.

1990-1994 онд Монгол улсын Багшийн дээд сургуулийн Зураг урлалын тэнхимд зураасан зураг, хар зураг, уран зургийн багшаар ажиллаж эхэлжээ. Ажиллаж байх хугацаандаа тус сургуульд “Төмөр бар”-ын анхны урланг үүсгэн байгуулж, улмаар 1993 онд анхны төгсөлтөө төгсгөж байсан.

3.Уянга 1994 онд анхны бие даасан “График” уран бүтээлийн үзэсгэлэнгээ Монголын Урчуудын эвлэлийн хорооны үзэсгэлэнгийн танхимд дэлгэн нийтийн хүртээл болгосон юм. Тус үзэсгэлэнгийн онцлог нь зураасны тоглолтоос бий болсон гэрэл сүүдрийг нийтэд хүргэхийг илүү их зорьсон харагддаг. Энэхүү үзэсгэлэнд зураасан зургийн төрөл болох төмөр бар, модон бар, хулдаасан бар, монотип, чулуун барын 99 ширхэг бүтээл тавигджээ. “График” бие даасан үзэсгэлэн нь үзэгчид болон уран бүтээлчдээс талархлыг ихэд хүлээсэн. 1995 онд Монголын урчуудын эвлэлийн хорооны шагнал хүртэж, улмаар зураасан зургийн урлагийг хөгжүүлэх эрхэм бөгөөд том хариуцлагатай үүрэг хүлээн авчээ.

2014 оноос Дүрслэх урлагийн академийн зураасан зургийн урлангийн багшаар ажиллаж эхлээд, бар зургийн техникүүд болох төмөр бар, өнгөт модон бар, монотипын арга техникүүдийг мэргэжлийн оюутнууд болон зураасан зургийн залуу зураач нарт зааж хөгжүүлж эхэлсэн байна (Зураг 6).



Зураг 6. 3.Уянга зураасан зургийн оюутнуудын хамт. Богд Хаань ордон музей, 2014 он

2015 онд З.Уянга багшийн санаачилгаар, СУИС-аас дэмжин, зураасан зургийн “Эко” урлан байгуулсан юм. Эко урлан монголын суурь зураасан зургийн урлагт торгон барын урлагийн хөтөлбөр анх суулгаж, мэргэжлийн уран бүтээлийн төвшинд нэвтрүүлжээ. Тус торгон барын Эко урлан байгуулагдсанаар оюутан сурагчдад зураасан зургийн нэг төрөл болох уг техник, технологи, арга ажиллагааны талаар дэлхийн жишигт нийцэхүйц боловсрол эзэмшүүлж байна. Улмаар оюутан залуусын бүтээлд эрс өөрчлөлт гарч, монголын мэргэжлийн нийт уран бүтээлчдийн дунд зохиогдсон “Гранд-Арт”, “Алтан бийр” зэрэг уралдаант том үзэсгэлэнгүүдийн тэргүүн болон шагналт байруудад тогтмол шалгарч байгаагаар үр дүн нь илэрч байна. Энэ бүх хичээнгүй хөдөлмөр бүтээл, сургалтын арга барилыг нь сургуулийн захиргаанаас дэмжиж, 2018 онд Монгол улсын Соёл урлагийн их сургуулийн Хүндэт профессор цол олгосон. З.Уянга багш суралцагч оюутнууддаа өөр өөрийн онцлог дүр төрх, өнгө, арга барил суулгаж, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх талаар ихээхэн анхааран ажиллаж байна. Жишээ дурдахад, ДУА-ийн 2015 оны төгсөгч Б.Даваасүрэнгийн “Цэцэгс” торгон барын дөрвөн цуврал бүтээл нь тус оны төгсөлтийн шилдэг бүтээлээр шалгарч байсан (Зураг 7). ДУА-ийн 2022 оны төгсөгч Н.Болорчимэгийн “Хүний үг” хэмээх өнгөт модон барын цуврал бүтээлүүд шилдэг дипломын ажлаар шалгарч, зураасан зургийн урлагийн орчин үеийн хэв шинж, өнгө будаг хослолын нарийн мэдрэмжийг гаргаж өгсөн нь үзэгч олон болон уран бүтээлч багш нараас өндөр үнэлгээг авч, МУЭ-ийн нэрэмжит талархал, дурсгалын зүйлийн хамт МУЭ-ийн ерөнхийлөгч П.Ганбатаас гардуулан өгсөн байна (Зураг 8).

З.Уянга нь 2014 оноос тус академид тасралтгүй багшилж, олон арван шавь нарыг зураасан зургийн мэргэжлээр төгсгөсөн багш юм. Тодруулбал, З.Уянга багш нийт найман удаагийн төгсөлтөөр бакалавр, магистрын 80 гаруй зураасан зургийн мэргэжлийн оюутнуудыг удирдан төгсгөсөн байна.



Зураг 7. Б.Даваасүрэн “Цэцэгс” торгон бар дөрвөн цуврал бүтээл, 70x70 см



Зураг 8. З.Уянга, Д.Уранчимэг, Н.Болорчимэг, П.Ганбат

Дүгнэлт

Илья Репиний нэрэмжит дүрслэх урлагийн 260 гаруй жилийн түүхтэй дэг сургалтыг монголын дүрслэх урлагт 70 гаруй жил хөгжүүлэн бойжуулсан энэхүү академийн 70 гаруй төгсөгчийн нүсэр их хүч хөдөлмөр, цаг хугацаа, оюун сэтгэлгээ, уран чадварыг хүндлэх нь зүйн хэрэг. Энэхүү дэг сургалт XX зуунаас XXI зууны шилжилтийн үед хэрхэн хувьсан өөрчлөгдөж, улам бүр өсөн хөгжиж байгааг анхааралтай ажиглан, бид ч сургалт, судалгаандаа цаашид нэвтрүүлэн төлөвшүүлэх шаардлагатай байна. Тус академийн төгсөгч Я.Оюунчимэг, З.Уянга багш нарын уран бүтээл, заах арга зүйн талаар урлахуйн ухааны үүднээс судалж нэгтгэн дүгнэсэн болно.

Илья Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академийн төгсөгч Я.Оюунчимэг (1977), түүний шавь З.Уянга (1989) нарын суралцагчдад бүтээлч сэтгэлгээ, уран бүтээлч хандлага төлөвшүүлэн ажилладаг арга ажиллагааг тэдний боловсруулсан хэрэгжүүлсэн сургалтын хөтөлбөр, түүний гүйцэтгэл, танхимын заах арга зүй, дипломын ажил удирдах арга барил, суралцагч бүрийн онцлогт тохируулан зөвлөн ажиллах зэргийг дидактикийн болон урлахуйн ухааны онолын үүднээс судалж, дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Тэд монголын орчин үеийн урлаг, социализмын үеийн урлагийн хоорондох шилжилтийн түүхэн үед уран бүтээл, сурган хүмүүжүүлэх ажлаа тасралтгүй хийж ирсэн бөгөөд монголын зураасан зургийн урлагийг хөгжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн байдаг. Хоёр уран бүтээлчийн

уран сэтгэмж, бүтээл боловсруулалт, үзэл бодлоор олж авсан амжилт нь сүүлийн хэдэн арван жилд монголын дүрслэх урлаг гоо зүйн хөгжилд бүх талаар чухал нөлөө үзүүлсэн байна.

2. И.Е.Репиний нэрэмжит Дүрслэх урлагийн академид суралцсан нь Я.Оюунчимэг (1977), түүний шавь З.Уянга (1989) нарын урлагийн өндөр боловсрол, уран чадвар, уран бүтээлчийн сэтгэлийн хат, тэсвэр тэвчээр, оргилуун хүсэл тэмүүлэл суулган өгсөн байна.

Номзүй

1. Дулам, С. 2011. *Монгол бэлгэдэл зүй II. Өнгийн бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй*. Улаанбаатар, Монгол Улс: Битпресс.
2. Дулам, С. 2011. *Монгол бэлгэдэл зүй. Дүрсийн бэлгэдэл зүй. Дохио зангааны бэлгэдэл зүй*. Улаанбаатар, Монгол улс: Битпресс.
3. Майдар, Д. 1982. *Монголын түүх соёлын дурсгалт зүйлс*. Улаанбаатар, Монгол Улс.
4. Майдар, Д. 1987. *Монгол график*. Улаанбаатар, Монгол Улс.
5. Содномцэрэн, Л. 1976. *Орчин үеийн монголын дүрслэх урлаг*. Улаанбаатар, Монгол Улс.
6. Сономцэрэн, Л., Батчулуун Л. 1989. *Монголын Дүрслэх Урлагийн товч түүх*. Улаанбаатар, Монгол Улс.
7. Уранчимэг, Д. 2023. *Социализм Монголын дүрслэх урлагт*. Улаанбаатар, Монгол Улс: Юнипресс.
8. Чойжилсүрэн, Д. 1959. *Буриад модон барын номын таван гарчиг*. Улаанбаатар, Монгол Улс.
9. Шүгэр, Ц. 1991. *Монгол модон барын ном*. Улаанбаатар, Монгол Улс.